



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 648

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын дээд шүүхийн Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 52,000,000.00 (тавин хоёр сая) төгрөгийн балансын үнэ бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн автомашиныг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа Багахангай, Налайх дүүргийн шүүхийн Тамгын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга Ж.Наранпүрэв, Багахангай, Налайх дүүргийн шүүхийн Тамгын газрын дарга Б.Бээжин нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0001273

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн
648... дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРААС БАГАХАНГАЙ, НАЛАЙХ ДҮҮРГИЙН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД
ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

Д/д	Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Цаашид ашиглах (жил)
1	Ниссан Урбан, 81-52 УНЛ, JN1TA4E2520013114, Суудлын автомашин	2013/2013	7380	52,000,000.00	52,000,000.00	8,000,000.00	4
НИЙТ ДҮН							
				52,000,000.00	52,000,000.00	8,000,000.00	4
				(тавин хоёр сая)	(тавин хоёр сая)	(найман сая)	-